

ОЮУТНУУДЫН СУРАХ СЭДЛИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

М.Нарантуяа¹, Д.Отгонцэрэн¹, Б.Хулан¹,

¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль
Khulan.b@mnums.edu.com

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Б.Оюунчимэг

Хураангуй

Бидний төгсгөж буй мэргэжилтнүүд өнөөгийн эрүүл мэндийн салбарт шаардлагатай чадваруудыг эзэмшиж, эрүүл мэндийн болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэн болж чадах эсэх нь тухайн оюутны сурах сэдэлтэй холбоотой юм. Сэдэл-Бие хүнийг үйл ажиллагаа хийхэд хүргэж буй дотоод сэтгэлийн хүч. Сэдэл нь тодорхой зорилготавьсан бие хүний зорилгоо биелүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн чиглүүлэгч дотоод сэтгэлийн өдөөгч хүч, хүний зан үйлийн эхлэл, идэвх, үйлдэл хийгдэх үндэс болдог. Сэдэл нь хэрэгцээтэй ямагт холбоотой байдаг. Иймд Дархан-Уул аймгийн Анагаахын сургуулын Оюутнуудын сурах сэдлийг үнэлэн, үр дүнд үндэслэн дүгнэлт хийх зорилгоор энэхүү судалгааг явуулсан болно. Судалгааг Г.И.Ильинагийн боловсруулсан гурван үзүүлэлт бүхий асуулгаар оюутны сурах сэдлийг тодорхойлох, мэдлэг эзэмших, мэргэжил эзэмших, диплом авах сурах сэдлийн харьцуулалт хийж дараах үр дүнг гаргасан.

- Мэдлэг эзэмших-Мэдлэгт эрмэлзэж сонирхох сэдлийн дундаж хэмжүүр 8,3 оноо буюу нийт суралцагчдын 37%(62)
- Мэргэжил эзэмших-Мэргэжлийн мэдлэг эзэмших ба өөртөө чухал чанарууд төлөвшүүлэх сэдлийн дундаж хэмжүүр 6,7 оноо буюу нийт суралцагчдын 30%(50)
- Диплом авах-Нийгмийн шаардлагаар, ажил хөдөлмөрийн эрэлтийн байдлаас, цалин хөлсөөс хамаарах зэрэг сэдлийн дундаж хэмжүүр 7,5 оноо буюу нийт суралцагчдын 24%(40) ба 3 хэмжүүрт адил оноо өгсөн 9%(15) тус тус эзэлж байна.

ТҮЛХҮҮР ҮГ: Сэдэл, хэрэгцээ, суралцахуй, нийгэм, мэргэжил, диплом

Үндэслэл

Өнөөгийн нийгэмд эрүүл мэндийн салбар дахь эмнэлгийн мэргэжилтний үүрэг хариуцлага байнга өсөн дэвшиж байх шаардлагатай, ялангуяа өвчин болон түүний урьдчилан сэргийлэлтийн талаар нийгмийн шинэ ойлголтууд хурдацтай нэмэгдэж буй өөрчлөлтөнд тулгуурлан, их сургууль нь нийгмийн хэрэгцээ, хүлээлтийг хангах

мэргэжилтнүүдийг бэлтгэх, сургалт үйлчилгээний шинэ арга хэлбэрийг эрэлхийлж хэрэгжүүлэх шаардлагатай. Сурахуй нь суралцагч өөрт хэрэгтэй мэдлэг туршлага, хэрэгцээ зэрэгтээ тулгуурлан өөрт хэрэгтэй мэдлэг арга барил чадварыг бие даан эзэмших, шинэ мэдлэг бүтээх, мэдсэн сурсанаа өөрөө хянаж үнэлэх, өөрийгөө хөгжүүлэх бүтээлч процесс. Бидний төгсгөж буй мэргэжилтнүүд өнөөгийн эрүүл мэндийн салбарт шаардлагатай чадваруудыг эзэмшиж, эрүүл мэндийн болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэн болж чадах эсэх нь тухайн оюутны сурах сэдэлтэй холбоотой юм.

Сэдэл-Бие хүнийг үйл ажиллагаа хийхэд хүргэж буй дотоод сэтгэлийн хүч.

Сэдэл нь тодорхой зорилготавьсан бие хүний зорилгоо биелүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн чиглүүлэгч дотоод сэтгэлийн өдөөгч хүч, хүний зан үйлийн эхлэл, идэвх, үйлдэл хийгдэх үндэс болдог. Сэдэл нь хэрэгцээтэй ямагт холбоотой байдаг. Хэрэгцээ-ямар нэг зүйл шаардлагатай болох байдал. Бие хүний хэрэгцээ, үнэт зүйл сонирхол зэрэг нь үйл ажиллагаа, харилцаанд тэднийг чиглүүлж, идэвхжүүлж байдаг өвөрмөц хүчин зүйлс юм. Сэтгэл зүйчдийн үзэж байгаагаар “Хүн аливаа үйл ажиллагааг ухамсартай хийх явцад түүний оюун ухаан хөгждөг” юм байна гэж үздэг. Ингэхдээ тэрхүү үйл ажиллагаа нь тэдний хэрэгцээ, сэдэл зэргийг хангахад чиглэсэн байвал хүн тэр үйл ажиллагааг гадны шахалтгүйгээр өөрийн идэвхи санаачлагаар хийдэг. Тархины идэвхжил нь хөдөрмөр ба үйлдлийн үр дагавараас биш, зөвхөн хөдөлмөрлөх сэдлээс хамаарч байсныг тархинаас ялгарах соронзон долгионы хэмжилтээр тодорхойлжээ. Манай нийгэм сүүлийн олон арван жилийн турш зөвхөн нийгмийн хэрэгцээ сонирхолыг гол болгож ирсэн. Гэвч даяаршилын эрин үед сургалтаа орчин үеийн байдлаар зохион явуулье гэвэл хүссэн хүсээгүй суралцагчдын хэрэгцээ, сонирхолыг судалж, заавал харгалзан үзэх шаардлагатай учирсан. Иймд суралцагчдын хэрэгцээ, сонирхолыг сургууль, багш нар юуны түрүүнд судалж, түүндээ үндэслэн багш нар сургалтын хөтөлбөрөө боловсруулах, тэдгээрээс суралцагч сонирхсон хөтөлбөрөө сонгон судлаж зах зээлийн өрсөлдөөнт нийгэмд ажиллаж

амьдрах чадвар бүхий бие хүн төлөвшүүлэх явдал юм.

Зорилго

Оюутнуудын сурах сэдлийг үнэлэн, үр дүнд үндэслэн дүгнэлт хийх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүллээ. Үүнд:

- Г.И.Ильинагийн боловсруулсан гурван үзүүлэлт бүхий асуулгаар оюутны сурах сэдлийг тодорхойлох
- 3 төрлийн сурах сэдлийн харьцуулалт хийж дүгнэлт гаргах

Судалгааны материал арга зүй

Судалгааны асуумж ба боловсруулалт: Г.И.Ильинагийн боловсруулсан гурван үзүүлэлт бүхий асуулгаар оюутны сурах сэдлийг тодорхойлох: Үүнд:

- **Мэдлэг эзэмших** - Мэдлэгт эрмэлзэж сонирхох
- **Мэргэжил эзэмших** - Мэргэжлийн мэдлэг эзэмших ба өөртөө чухал чанарууд төлөвшүүлэх
- **Диплом авах** - Нийгмийн шаардлагаар, ажил хөдөлмөрийн эрэлтийн байдлаас, цалин хөлсөөс хамаарах зэрэг сурах сэдлүүдийг 50 асуулга даалгавраас бүрдсэн.
- Тухайн асуумжийг **зөвшөөрч байгаа бол “+” зөвшөөрөөгүй бол “-”** илэрхийлнэ.

Судалгааны ажлын үр дүнд статистик боловсруулалтын SPSS-24.0 программыг ашиглан мэдээллийн бааз үүсгэн, мэдээлэл шивэх үйлдлүүдийг гүйцэтгэж үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр (дунджийн хэлбэлзэл) – ийн үзүүлэлт, стандарт хазайлт, тоон үзүүлэлт хоорондын хамаарлыг тодорхойлохдоо Spearman корреляцийн коэффициент ашиглан үр дүнг нэгтгэв. **Судалгаанд** Сэтгэц оношлогооны практик арга болох асуулгын аргыг ашигласан. Судалгаанд АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуудийн төгсөлтийн өмнөх сургалтанд хамрагдаж байгаа 163 оюутан судалгаанд оролцсон.

Судалгааны үр дүнгийн боловсруулалт, асуулгын түлхүүр

“Мэдлэг эзэмших” сэдлийн хувьд дараах өгүүлэмжүүдийг зөвшөөрсөн бол-4-р өгүүлэмжид 3,6, 17-рт 3,6; 26-рт 2,4 оноо;

Харин дараах өгүүлэмжүүдийг зөвшөөрөөгүй бол 28-р өгүүлэмжид 1,2; 42-рт-1,8 оноо тус тус өгнө. Авах ёстой дээд оноо-12,6

“Мэргэжил эзэмших” сэдлийн хувьд дараах өгүүлэмжүүдийг зөвшөөрсөн бол доорх оноонууд өгнө. Үүнд 9-р өгүүлэмжид-1,0; 31-рт 2,0; 33-рт-2,0; 43-рт 3,0; 48-рт 1,0; 49-рт 1,0 оноо тус тус өгнө. Авах дээд оноо 10,0


“Диплом авах” сэдлийн хувьд 11-р өгүүлэмжийг зөвшөөрөөгүй бол 3,5 оноо, дараах дугаарууд бүхий өгүүлэмжүүдийг зөвшөөрсөн бол;

24-р өгүүлэмжид 2,5; 35-рт 1,5; 38-рт 1,5; 44-рт 1,0 оноо тус тус өгнө. Авах дээд оноо 10,0

5,13,30,39 өгүүлэмжүүд саармаг учир боловсруулалтанд оруулахгүй.

Эхний хоёр хэмжүүрээр сэдэл давамгайлж байвал оюутан мэргэжлээ зөв сонгосон бөгөөд мэргэжилдээ сэтгэл хангалуун байгаа гэдгийг гэрчилж байгаа юм.

Хүснэгт 1 Сурах сэдлийн үр дүн



Хүснэгт 1 ээс харахад 3 сэдэл нэг нь давамгайлах биш жигд оноо авсан нь харагдаж байна. Иймээс 3 үзүүлэлт жигд үр дүн үзүүлж байна.

Дүгнэлт

Г.И.Ильинагийн боловсруулсан гурван үзүүлэлт бүхий асуулгаар 163 оюутны сурах сэдлийг тодорхойлоход

Мэдлэг эзэмших - Мэдлэгт эрмэлзэж сонирхох сэдлийн дундаж хэмжүүр 8,3 оноо буюу нийт суралцагчдын 37%(62)

Мэргэжил эзэмших - Мэргэжлийн мэдлэг эзэмших ба өөртөө чухал чанарууд төлөвшүүлэх сэдлийн дундаж хэмжүүр 6,7 оноо буюу нийт суралцагчдын 30%(50)

Диплом авах - Нийгмийн шаардлагаар, ажил хөдөлмөрийн эрэлтийн байдлаас, цалин хөлсөөс хамаарах зэрэг сэдлийн дундаж хэмжүүр 7,5 оноо буюу нийт суралцагчдын 24%(40) ба 3 хэмжүүрт адил оноо өгсөн 9%(15) тус тус эзэлж байна.

Суралцагчид нийгмийн эрэлт хэрэгцээний дагуу сурах сэдэл нь ухамсартайгаар зохицуулагддаг бөгөөд судалгаанаас хархад 3 үзүүлэлт жигд үр дүн үзүүлж байна.